



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ 5 ТӨГРӨГ, 1000 ТӨГРӨГНИЙ ДЭВСГЭРТИЙГ ХУУЛЬ ЁСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛД ТООЦОХ, ГҮЙЛГЭЭНД ГАРГАХЫГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ 1993 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Улаанбаатар хот Дугаар 69 Монгол улсын Их Хурлаас ТОГТООХ нь: 1."Мөнгөн тэмдэгтийн хэв загварыг батлах тухай" Улсын Бага Хурлын 1992 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 32 дугаар тогтоолын дагуу хэвлэгдсэн "5 төгрөг", "1000 төгрөг"-ийн дэвсгэртийг Монгол Улсын хууль ёсны төлбөрийн хэрэгсэлд тооцсугай. 2.Бэлэн мөнгөний гүйлгээний байдал, хэрэгцээг харгалзан Банкны хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн "5 төгрөг", "1000 төгрөг"-ийн дэвсгэртийг гүйлгээнд гаргахыг Монголбанк (Д.МОЛОМЖАМЦ)-д зөвшөөрсүгэй. ДАРГА Н.БАГАБАНДИ ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.РИНЧИНДОРЖ